

*А. Монахзүмбэр*  
*Аудит, хяналт*  
*шалгалтын албаны*  
*дэргачин*  
*Д. ГАНДОЛГОР*



АРХАНГАЙ АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УДИРДАМЖ

2023 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 09

Эрдэнэбулган сум

Аймгийн Засаг даргын нөөц сан,  
тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд аудит,  
хяналт шалгалт хийх тухай

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол улсын Төсвийн тухай, Захиргааны ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон эрх бүхий байгууллагаас гарсан тогтоол шийдвэрүүд, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм", Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам", Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт", аймгийн "Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм" зэргийг тус тус үндэслэн аудит, хяналт шалгалтыг явуулна.

### Хоёр. Шалгалтын зорилго

2.1 Байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны үйл ажиллагаа, Засаг даргын нөөц сангийн зарцуулалтын байдалд аудит, хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдэнэ.

### Гурав. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

#### 3.1 Аудит, хяналт шалгалт хийх

3.1.1 Шалгалтын явцад холбогдох программ хангамж, ажлын байранд нэвтрэн шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангах;

3.1.2 Шалгалтын тэмдэглэлийн төсөлтэй танилцаж санал, тайлбар өгөх;

### 3.2 Аудит, хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллага:

3.2.1 Шаардлагатай тайлан мэдээ, холбогдох баримт материалыг ажлын хэсэгт шаардсан хугацаанд саадгүй гаргаж өгөх;

3.2.2 Аудит, хяналт шалгалтын дүнгээр гаргасан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх;

### 3.3 Аудит, хяналт шалгалт хийх ажлын хэсэг

3.3.1 Аудит, хяналт шалгалтыг явуулахдаа удирдамжийн хүрээнд ажиллах;

3.3.2 Шалгалтын ажлын явцад хамрагдаж буй байгууллага, газрын талаарх мэдээллийн нууцлалыг хадгалах;

3.3.3 Шалгалтыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу чанартай, бие даасан байдалтай гүйцэтгэх;

### 3.4 Хяналт шалгалтад шаардагдах хөрөнгө нөөц

3.4.1 Санхүүгийн нөөц: Бичиг хэргийн материал

3.4.2 Техник хэрэгсэл: Компьютер, ширээ, сандал, бусад тоног төхөөрөмж, техник хэрэгсэл

### **Дөрөв. Шалгалтын хамрах хүрээ, бүрэлдэхүүн, хугацаа**

4.1. Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны үйл ажиллагаа, Засаг даргын нөөц сангийн зарцуулалтын байдалд аудит, хяналт шалгалт хийнэ.

4.2. А.Буяндэлгэр- Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, Ахлах дотоод аудитор /Ажлын хэсгийн ахлагч/

Б.Мөнх-Эрдэнэ - Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч

Н.Нямсүрэн – Дотоод аудитор

4.3. 2023 оны 06 дугаар сарын 15-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал 12 хоногт багтаан хийж гүйцэтгэнэ.

4.4 Шалгалтыг Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 5.7 дугаар зүйлийг үндэслэн явуулна.

### **Тав. Шалгалтад хамрагдах асуудлууд**

5.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, хамтын гэрээ, дүрэм журмууд стандартын хэрэгжилт;

5.2. Ажиллагсдын үр дүнгийн гэрээнүүдийн хэрэгжилт, удирдлагын гаргасан шийдвэрүүд хууль тогтоомж, дүрэм журамд хэрхэн нийцсэн байдал;

5.3. Байгууллагын дотоод журмын хэрэгжилт, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын зохион байгуулалт, хийсэн ажил түүний үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөх

5.4. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцэл гаргалтын байдал

5.5. Харилцах, кассаас зарцуулсан мөнгөний баримтын бүрдэлт, хууль эрх зүйн үндэслэл, зарцуулалт, үр дүн тайлагналт

5.6. Улсын төсвийн болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив, зээл тусламж, сангийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн зориулалт, зарцуулалт, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал, ашиглалт, зээлийн эргэн төлөлт, үр өгөөжийн байдал

5.7. Шалгагдах байгууллагын ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал, зарцуулалт;

5.8. Шалгагдах байгууллагуудын өмч хөрөнгийн бүртгэл, тооллого тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт;

5.9. Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх;

5.10. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээ түүний хэрэгжилтийг дүгнэсэн байдал;

5.11. Өмнө хийгдсэн шалгалтын төлбөр зөрчил түүний барагдуулалт, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал арилсан эсэхэд дүгнэлт өгөх;

5.12. Өргөдөл хүсэлтийг судалж, шийдвэрлэх /Шаардлагатай тохиолдолд өмнөх онуудын баримт материалыг татан үзнэ/

#### **Зургаа: Шалгалтын дүнг гаргах**

6.1 Шалгалтад хамрагдсан асуудлаар дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын ажлын нэгдсэн дүнг "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 5.10-д заасны дагуу шалгагдсан байгууллагын удирдлагыг байлцуулан танилцуулж, санал хүсэлтийг тусгасан хурлын тэмдэглэлийг гаргуулна.

6.2 Шалгалтын дүнгийн талаар шалгалт дууссанаас хойш "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 5.11-д заасны дагуу ажлын 5 хоногийн дотор танилцуулга бичиж, албаны даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулах

6.3 "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2-д заасны дагуу ажлын биелэлтэд хяналт тавина.